

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
МДГОУХАН	Монгол дахь Германы Олон улсын Хамтын ажиллагааны нийгэмлэг
БОАЖС	Байгаль орчин аялал жуулчлалын сайд

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6-7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8-9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11-12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал.....	20-21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БОГДХАН УУЛЫН ДАРХАН ЦААЗАТ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.ПҮРЭВЖАВ ТАНАА

2021.02.25 № 07/486
танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам 76 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна. Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч, материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	152 088 867,15	281 352 879,17
33	АВЛАГА	4 000 000,00	160 669 900,00
33300	Татаас санхүүжилтийн авлага	4 000 000,00	160 669 900,00
35	БАРАА МАТЕРИАЛ	148 088 867,15	120 682 979,17
354	Хангамжийн материал	83 588 867,15	54 932 979,17
35410	Бичиг хэргийн материал	4 292 068,00	1 775 100,00
35420	Аж ахуйн материал	10 192 209,20	8 367 718,20
35430	Сэлбэг хэрэгсэл	4 105 000,00	-
35440	Түлш шатах тослох материал	7 655 500,00	9 239 500,00
35470	Бусад хангамжийн материал	57 344 089,95	35 550 660,97
35500	Биологийн хөрөнгө	63 000 000,00	65 000 000,00
35600	Мал амьтад	1 500 000,00	750 000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	614 988 121,66	804 168 064,78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	614 988 121,66	804 168 064,78
392	Биет хөрөнгө	355 042 121,66	544 222 064,78
39201	Барилга, байгууламж	217 772 993,00	217 772 993,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12 990 050,10)	(21 908 950,02)
39203	Авто тээврийн хэрэгсэл	97 389 250,00	157 225 573,78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(69 568 589,86)	(60 976 552,22)
39205	Машин, тоног төхөөрөмж	104 415 313,66	101 829 786,66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(45 744 205,68)	(40 435 558,14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29 284 093,54	38 581 693,54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5 631 113,68)	(11 867 162,83)
39214	Бусад үндсэн хөрөнгө	70 794 694,80	206 785 942,80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(30 680 264,02)	(42 785 701,79)
393	Биет бус хөрөнгө	259 946 000,00	259 946 000,00
39303	Програм хангамж	259 946 000,00	259 946 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	767 076 988,81	1 085 520 943,95
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	4 000 000,00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4 000 000,00	-
413	Өглөг	4 000 000,00	-
41361	Байгууллагад өгөх өглөг	4 000 000,00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	763 076 988,81	1 085 520 943,95
51	Засгийн газрын хувь оролцоо	763 076 988,81	1 085 520 943,95
511	Засгийн газрын оруулсан капитал	721 519 092,36	721 519 092,36
51101	Өмч: -төрийн	721 519 092,36	721 519 092,36
512	Хуримтлагдсан үр дүн	16 033 681,43	338 477 636,57
51210	Өмнөх үеийн үр дүн	(39 122 543,16)	16 033 681,43
51220	Тайлант үеийн үр дүн	55 156 224,59	322 443 955,14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25 524 215,02	25 524 215,02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	767 076 988,81	1 085 520 943,95

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	682 165 504,89	1 136 443 171,38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	295 383 004,89	125 427 563,38
120	Нийтлэг татварын бус орлого	275 465 195,78	125 427 563,38
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	275 465 195,78	120 227 563,38
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	159 595 180,00	20 980 260,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	115 870 015,78	99 247 303,38
120009	Бусад орлого	-	5 200 000,00
122	Тусламжийн орлого	19 917 809,11	-
122001	Хандив, тусламж (дотоод)	19 917 809,11	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	386 782 500,00	1 011 015 608,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	386 782 500,00	573 050 500,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	386 782 500,00	573 050 500,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	437 965 108,00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс		14 382 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс	-	407 054 108,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	16 529 000,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	594 765 863,42	813 999 216,24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	594 765 863,42	813 999 216,24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	545 749 344,66	763 647 966,17
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	313 945 106,42	383 560 536,79
210101	Цалин	271 629 906,42	264 831 467,98
210102	Нэмэгдэл цалин	33 189 200,00	83 355 100,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9 126 000,00	35 373 968,81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39 830 038,33	45 668 794,33
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	27 208 528,37	32 579 591,24
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3 155 378,49	3 051 923,83
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2 524 302,39	3 136 649,72
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	631 076,10	627 329,92
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	6 310 752,98	6 273 299,63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4 509 975,80	5 041 233,83
210301	Гэрэл цахилгааны зардал	2 598 700,00	1 836 027,50
210302	Түлш, халаалтын зардал	1 003 775,80	2 297 706,33
210303	Цэвэр, бохир усны зардал	907 500,00	907 500,00
2104	Хангамж, бараа материалын зардал	28 630 836,69	60 324 429,00
210401	Бичиг хэргийн материал	7 229 886,00	6 441 468,00
210402	Тээвэр, шатахууны зардал	6 330 000,00	21 556 700,00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	2 008 615,69	2 632 100,00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	2 386 735,00	26 494 161,00
210408	Бараа материал актасны зардал	10 675 600,00	3 200 000,00

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3 333 800,00	4 105 000,00
210604	Урсгал засвар	3 333 800,00	4 105 000,00
2107	Томилолт, зочны зардал	3 012 000,00	3 520 000,00
210702	Дотоод томилолтын зардал	3 012 000,00	3 520 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	84 483 325,00	190 034 744,98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	81 233 159,00	186 824 366,98
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1 485 000,00	1 485 000,00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	784 836,00	433 328,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	795 230,00	1 107 250,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	185 100,00	184 800,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68 004 262,42	71 393 227,24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14 016 674,00	6 218 048,58
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53 987 588,42	65 175 178,66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49 016 518,76	50 351 250,07
2132	Бусад урсгал шилжүүлэг	15 401 900,00	16 471 420,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15 401 900,00	16 471 420,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33 614 618,76	33 879 830,07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33 614 618,76	33 879 830,07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	87 399 641,47	322 443 955,14
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (IV)	32 243 416,88	-
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	6 643 416,88	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	25 600 000,00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4=145-225)	(32 243 416,88)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5=3+4)	55 156 224,59	322 443 955,14

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	557 205 680,00	1 031 995 868,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	170 423 180,00	20 980 260,00
120	Нийтлэг татварын бус орлого	170 423 180,00	20 980 260,00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	170 423 180,00	20 980 260,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	170 423 180,00	20 980 260,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	386 782 500,00	1 011 015 608,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	386 782 500,00	573 050 500,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	386 782 500,00	573 050 500,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	437 965 108,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс	-	14 382 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс	-	407 054 108,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт	-	16 529 000,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	557 205 680,00	886 327 760,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	557 205 680,00	886 327 760,00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	508 189 161,24	675 306 609,93
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	315 911 844,75	383 560 536,79
210101	Үндсэн цалин	232 255 044,75	264 831 467,98
210102	Нэмэгдэл	66 378 800,00	83 355 100,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17 278 000,00	35 373 968,81
2102	Ажил олгогчоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	37 863 300,00	45 668 794,33
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	25 747 000,00	32 579 591,24
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3 029 200,00	3 051 923,83
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2 423 200,00	3 136 649,71
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	605 800,00	627 329,92
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	6 058 100,00	6 273 299,63
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	4 509 975,80	5 166 233,83
210301	Гэрэл цахилгааны зардал	2 598 700,00	1 836 027,50
210302	Түлш, халаалтын зардал	1 003 775,80	2 340 206,33
210303	Цэвэр, бохир усны зардал	907 500,00	990 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	24 075 415,69	31 060 300,00
210401	Бичиг хэрэг	5 783 900,00	2 869 500,00
210402	Тээвэр, шатахуун	12 877 000,00	23 140 700,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3 308 615,69	3 452 100,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2 105 900,00	1 598 000,00
2105	Нормативт зардал	18 694 500,00	6 150 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18 694 500,00	6 150 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19 179 800,00	196 000,00
210601	Багаж техник хэрэгсэл	12 000 000,00	196 000,00
210604	Урсгал засвар	7 179 800,00	-

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	3 012 000,00	3 520 000,00
210702	Дотоод албан томилолт	3 012 000,00	3 520 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84 942 325,00	199 984 744,98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	81 692 159,00	196 524 366,98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 485 000,00	1 485 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	784 836,00	433 328,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	795 230,00	1 107 250,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	185 100,00	184 800,00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	-	250 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
		-	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49 016 518,76	211 021 150,07
2132	Бусад урсгал шилжүүлэг	15 401 900,00	16 471 420,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15 401 900,00	16 471 420,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33 614 618,76	194 549 730,07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33 614 618,76	33 879 830,07
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		160 669 900,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	145 668 108,00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	145 668 108,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	145 668 108,00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	145 668 108,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	145 668 108,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(145 668 108,00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	721 519 092,36	25 789 215,02	(29 387 543,16)	717 920 764,22
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(9 735 000,00)	(9 735 000,00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			(39 122 543,16)	708 185 764,22
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(265 000,00)	-	(265 000,00)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	55 156 224,59	55 156 224,59
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	721 519 092,36	25 524 215,02	16 033 681,43	763 076 988,81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	322 443 955,14	322 443 955,14
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	721 519 092,36	25 524 215,02	338 477 636,57	1 085 520 943,95

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	593 050 500,00	594 030 760,00	(980 260,00)	100.1
УРСГАЛ ЗАРДАЛ	593 050 500,00	594 030 760,00	(980 260,00)	100.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	573 495 900,00	543 679 509,93	29 816 390,07	94.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	396 966 000,00	383 560 536,79	13 405 463,21	96.6
Үндсэн цалин	275 844 900,00	264 831 467,98	11 013 432,02	96.0
Нэмэгдэл	83 355 100,00	83 355 100,00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	37 766 000,00	35 373 968,81	2 392 031,19	93.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53 527 100,00	45 668 794,33	7 858 305,67	85.3
Тэтгэврийн даатгал	37 648 500,00	32 579 591,24	5 068 908,76	86.5
Тэтгэмжийн даатгал	3 969 600,00	3 051 923,83	917 676,17	76.9
ҮОМШӨ-ний даатгал	3 175 700,00	3 136 649,71	39 050,29	98.8
Ажилгүйдлийн даатгал	793 900,00	627 329,92	166 570,08	79.0
Эрүүл мэндийн даатгал	7 939 400,00	6 273 299,63	1 666 100,37	79.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6 664 800,00	5 166 233,83	1 498 566,17	77.5
Гэрэл, цахилгаан	3 298 700,00	1 836 027,50	1 462 672,50	55.7
Түлш, халаалт	2 376 100,00	2 340 206,33	35 893,67	98.5
Цэвэр, бохир ус	990 000,00	990 000,00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	29 346 500,00	29 321 300,00	25 200,00	99.9
Бичиг хэрэг	1 951 400,00	1 950 500,00	900,00	100.0
Тээвэр, шатахуун	23 157 100,00	23 140 700,00	16 400,00	99.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 632 100,00	2 632 100,00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 605 900,00	1 598 000,00	7 900,00	99.5
Томилолт, зочны зардал	3 527 900,00	3 520 000,00	7 900,00	99.8
Дотоод албан томилолт	3 527 900,00	3 520 000,00	7 900,00	99.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83 463 600,00	76 442 644,98	7 020 955,02	91.6

**Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	79 931 600,00	72 982 266,98	6 949 333,02	91.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 485 000,00	1 485 000,00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	494 000,00	433 328,00	60 672,00	87.7
Тээврийн хэрэгслийн татвар	1 117 900,00	1 107 250,00	10 650,00	99.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	185 100,00	184 800,00	300,00	99.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250 000,00	250 000,00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19 554 600,00	16 471 420,00	3 083 180,00	84.2
Бусад урсгал шилжүүлэг	19 554 600,00	16 471 420,00	3 083 180,00	84.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19 554 600,00	16 471 420,00	3 083 180,00	84.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	593 050 500,00	560 150 929,93	32 899 570,07	94.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	573 050 500,00	539 170 669,93	33 879 830,07	94.1
Улсын төсвөөс санхүүжих	573 050 500,00	539 170 669,93	33 879 830,07	94.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20 000 000,00	20 980 260,00	(980 260,00)	104.9
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20 000 000,00	20 980 260,00	(980 260,00)	104.9
АЖИЛЛАГСАДЫН ТОО	41	41	-	-
Удирдах ажилтан	1	1	-	-
Гүйцэтгэх ажилтан	26	26	-	-
Үйлчлэх ажилтан	8	8	-	-
Гэрээт ажилтан	6	6	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /төгрөгөөр/
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	437 965 108,00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	437 965 108,00
Бараа, үйлчилгээний зардал	-	277 295 208,00
Хангамж, бараа материалын зардал	-	1 739 000,00
Бичиг хэрэг	-	919 000,00
Шуудан холбоо, интернет	-	820 000,00
Нормативт зардал	-	6 150 000,00
Нормын хувцас зөөлөн эдлэл	-	6 150 000,00
Эд хогшил худалдан авах	-	3 800 000,00
Багаж, техник, хэрэгсэл	-	3 800 000,00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	257 026 208,00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	257 026 208,00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	8 580 000,00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	8 580 000,00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	160 669 900,00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	160 669 900,00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	437 965 108,00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	437 965 108,00
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс	-	14 382 000,00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн	-	407 054 108,00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	16 529 000,00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тус хамгаалалтын захиргааны Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Пүрэвжав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд хандив тусламжийн орлого болон хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгах, дутагдсан бараа материалтай холбоотой асуудлыг цэгцэлж байгууллагыг хохиролгүй болгох талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 11-нээс 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Нью Эстимэйтор аудит ХХК-ийн Захирал Т.Бүжидмаа, аудитор Ж.Үхэртар нар хариуцаж хэрэгжүүлэв.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 100 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны эрхэм зорилго нь Богдхан уулын дархан цаазат газрын экологийн тэнцвэрт байдлыг хадгалан байгалийн нөөц баялгийн хамгаалалт, ашиглалтын менежментийг зөв зохистой явуулах, Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн болон Байгаль орчны багц хуулиудын хэрэгжилтийг хангахад оршино.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Богдхан уулын байгалийн унаган төрх, ургамал амьтны аймгийг хамгаалах, өсгөн үржүүлэх, ан амьтныг нутагшуулах үйл ажиллагаа явуулна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Засгийн газрын 2020 оны 78 дугаар тогтоолоор баталсан “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоолоор баталсан “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль орчин, аялал, жуулчлалын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас тус төвийн тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгээгүй байна.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 312,561.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6,251.2 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 318,443.9 мянган төгрөгөөр буюу 42.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	4,000.0	160,669.9	156,669.9
Бараа материал	148,088.9	120,682.9	(27,406.0)
Үндсэн хөрөнгө	614,988.1	804,168.1	189,180.0
Нийт хөрөнгө	767,077.0	1,085,520.9	318,443.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	763,077.0	1,085,520.9	322,443.9
Өр төлбөр	4,000.0	-	(4,000.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	767,077.0	1,085,520.9	318,443.9

Авлага дансны үлдэгдэл 160,669.9 мянган төгрөг болж 156,669.9 мянган төгрөгөөр өссөн нь БОАЖС-ын 2020 оны А/307 тоот тушаалаар “Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн хэвийн үйл ажиллагааг хангах, сэргээн засварлах” тохижилтын ажилд зориулан эрх шилжүүлэн өгсөн хөрөнгийн үлдэгдэл санхүүжилтийг тус хамгаалалтын захиргааны нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн бөгөөд тус санхүүжилтийг зарцуулалгүй төсөвт төвлөрүүлснээс авлага үүссэн байна.

Авлага дансанд он удаан жил болсон барагдах боломжгүй эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 120,682.9 мянган төгрөг болж 27,406.0 мянган төгрөгөөр буурсан нь 4,105.0 ашиглалтгүй бараа материалыг данснаас хассан, 3,200.0 мянган төгрөгийн биологийн хөрөнгө /адуу/ хорогдсон, 14,537.1 мянган төгрөгийн хөрөнгийн шинжтэй бараа материалыг үндсэн хөрөнгөнд шилжүүлснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 804,168.1 мянган төгрөг болж 189,180.0 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө орлого авснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсөв болон нэмэлт санхүүжилтээр 145,668.1 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 94,149.9 мянган төгрөг, бараа материалын дансанд байсан үндсэн хөрөнгийн шинжтэй 14,537.1 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 593 тогтоолоор 26,074.3 мянга, ТӨБЗГ-ын А-1/1980 тоот албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу 25,741.2 мянга, нийт 51,815.5 мянган төгрөгийн акталсан хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,085,520.9 мянган төгрөг болж 322,443.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 454,277.7 мянган төгрөгөөр буюу 66.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт болон нэмэлт санхүүжилтийн орлого байна. Урсгал үйл ажиллагааны санхүүжилт нь өмнөх оны үзүүлэлтээс 186,268.0 мянган төгрөгөөр өссөн бол нэмэлт санхүүжилтийн орлого нь 437,965.1 мянган төгрөгөөр өсчээ. Энэ нь БОАЖС-ын 2020 оны А/307 тоот тушаалаар “Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн хэвийн үйл ажиллагааг хангах, сэргээн засварлах” тохижилтын ажил, БОАЖС-ын 2020 оны А/636 тоот тушаалаар “Дархан цаазат газрын Зайсангийн амны аялалын замыг хашаажуулах, том оврын хогийн суурилуулах” зэрэг ажлуудад зориулан дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 407,054.1 мянган төгрөгийн орлого, “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, чадавх бэхжүүлэх тухай” Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/762 тоот захирамжийн дагуу 14,382.0 мянган төгрөг хуваарилсан, мөн Сангийн сайдын 2020 оны 225 дугаар тушаалаар үйл ажиллагааны давсан орлогыг зарцуулах эрхийн хүрээнд 16,529.0 мянган төгрөгийн нэмэлт орлого бий болсноос тус тус шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 219,233.4 мянган төгрөгөөр буюу 36.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, хангамж бараа материалын зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал байна. Тайлант онд батлагдсан орон тоо 41 болж нэмэгдсэнтэй холбоотойгоор цалингийн зардал өссөн бол хангамж, бараа материалын зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн тухайд нэмэлт санхүүжилтийн дансаар орсон орлоготой холбогдон зардал өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 497,726.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 107,021.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 604,747.4 мянган төгрөгөөр баталсан. Энэ нь БОАЖЯ-ны тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Тогтвортой хөгжлийн зорилтыг хангах зорилгоор тус байгууллагын тайлант оны төсвийг нэмэгдүүлж баталсан байна. 2020 оны 11 сард Сангийн яамнаас тус байгууллагын төсөвт /цалингийн зардалд/ 11,696.9 мянган төгрөгөөр тодотгол хийж батлагдсан төсөв 593,050.5 мянган төгрөг болсон байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэх батлагдсан төсвийн 573,050.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 20,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 573,050.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 20,980.2 мянган төгрөг, нийт 594,030.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 560,150.9 мянган төгрөгийг зарцуулж 33,879.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 560,150.9 мянган төгрөг буюу 94.5 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшил зардлыг 13,405.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 7,858.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийг 7,020.9 мянган төгрөгөөр, ашиглалтын зардлыг 1,498.6 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 3,083.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 23,847.2 мянган төгрөгөөр, харуул хамгаалалтын зардал арга хэмжээ 13.2 мянган төгрөгөөр, гэрээт ажиллагсдын зардал арга хэмжээ 2,119.7 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж арга хэмжээ 3,083.2 мянган төгрөгөөр, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал арга хэмжээ 3,103.0 мянган төгрөгөөр, ургамал хамгааллын зардал арга хэмжээг 1,713.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 14,382.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 407,054.1 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 16,529.0 мянга, нийт 437,965.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх болон тэмцэхэд байгаль хамгаалагчдын чадавхийг бэхжүүлэхтэй холбоотой 14,382.0 мянга, Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн хэвийн үйл ажиллагааг хангах, сэргээн засварлах тохижилтын ажилд 157,712.0 мянга, урсгал зардалд 13,571.1 мянга, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаанд хийгдэх хилийн цэсийн багана, тэмдэг тэмдэглэгээ, нэвтрэх хаалга барихад зориулж 11,052.0 мянга, Дархан цаазат газрын Зайсангийн амны аялалын замыг хашаажуулах, том оврын хогийн сав суурилуулах зэрэг тохижилтын ажилд 80,578.1 мянга, нийт 277,295.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 160,669.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого байхгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6,175.1 мянган төгрөгийн зөрчилд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-					
Албан шаардлага	-	-					
Зөвлөмж	3	6,175.1	3	6,175.1	3	-	100.0
Нийт дүн	3	6,175.1	3	6,175.1	3	-	100.0

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 296,636.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8,986.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 239,468.7 мянган төгрөгийн шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудалд 1 албан шаардлага хүргүүлж, 48,360.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

2020 оны санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдэл дэх төсөвт байгууллагын өөрийн орлогын дүнг 8,986.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 7,880.2 мянга, төвлөрүүлэх

шилжүүлгийг 4,000.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байсныг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч уг зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Шилэн дансанд 3 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээтэй холбоотой гэрээ, гэрээ дүгнэсэн актыг байршуулаагүй 20 гүйлгээ, мөн нэр данс зөрсөн 16,489.7 мянган төгрөгийн орлого зарлагын 1,1 гүйлгээ, үйл ажиллагааны орлогын 3 гүйлгээ, төвлөрүүлэх шилжүүлэгтэй холбоотой 194,549.7 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээ, нийт 239,468.7 мянган төгрөгийн орлого зарлагын 7 гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 48,360.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тайлант онд Нийслэлийн эрүүгийн цагдаагийн газар, Авлигатай тэмцэх газраас Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд гурвалсан гэрээгээр газар ашиглаж буй буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглалтын байдалд хяналт тавих, хэрэг бүртгэлтэй холбоотой шалгалтын ажил зохион байгуулсан бөгөөд урьдчилсан байдлаар тус шалгалтын үр дүнд 660 иргэн, хуулийн этгээдэд зөрчил тооцуулах шаардлагатай гэж үзэн харьяа дүүргийн газар зохион байгуулалтын албанд мэдэгдэл хүргүүлсэн байна. Тус шалгалттай холбоотойгоор иргэн, хуулийн этгээдийн газар ашиглах гэрээний заалтууд /үүрэг/ бүрэн хэрэгжиж байгаа эсэх талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн 2020 оны 9 дүгээр сард нэгэн иргэнээс Toyota Prius 30 автомашиныг тус байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн байгаль хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулах зорилгоор сайн дурын үндсэн дээр өгсөн нь анхаарал татахуйц асуудал байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Хандив, тусламжийн орлого болон байгууллагын хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Буцалтгүй тусламжийн хүрээнд Монгол дахь Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс /GIZ/ “Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмрээ оруулах нь” SPACES төслийн хүрээнд төсөл хамтран хэрэгжүүлэгч БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газарт Toyota Land cruiser 76 автомашиныг 2020 оны 1 дүгээр сарын 02-нд хүлээлгэн өгсөн бөгөөд БОАЖЯ тус автомашиныг Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд олгосон байна. БОАЖЯ тус автомашиныг Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд албан ёсоор шилжүүлээгүй буюу тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь Монгол дахь Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн нэр дээр бүртгэлтэй байгаа юм. Тус нийгэмлэгээс тээврийн хэрэгслийн эзэмшигчийг өөрчлүүлэхээр Авто тээврийн үндэсний төвд хүсэлт гаргасан хэдий ч одоог хүртэл шийдэгдээгүй байна.

Тус хамгаалалтын захиргаа нь дээр дурдсан хөрөнгөнд бүртгэлгүй байгаа автомашиныг хүлээн авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж 4,860.4 мянган төгрөгийн шатахуун болон бусад зардлыг гаргасан байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаагаас гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; 14.4.5.бүх орлого; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл Төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрх, 14.2.1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах; гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Тусламж хандивын орлогыг бүртгээгүйгээс санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, автомашинтай холбоотой шатахуун болон засвар үйлчилгээний зардал гарснаар батлагдсан төсвийн хэтрэлт үүсэх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч автомашиныг хөрөнгөнд бүртгэх мөн хандив тусламжийн орлогын дүнг тодорхойлж үр дүнгийн тайланд тусгах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2020 онд БОАЖЯ-аас УНГ10-35 улсын дугаартай Land Cruiser 76 автомашиныг үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн. БОАЖЯ-д хэрэгжиж буй төслийн Монгол дахь Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс /GIZ/ "Авто тээврийн үндэсний төвд тээврийн хэрэгслийг БОАЖЯ-ны нэр дээр шилжүүлэн бүртгүүлэх хүсэлт өгч байсан боловч АТҮТ-с архиваас шүүлгэхэд БОАЖЯ одоо болтол өөрийн нэр дээр шилжүүлэг хийгээгүй төслийн нэр дээр бүртгэлтэй байна. БОАЖЯ-д удаа дараа хандсан боловч 2020 ондоо багтаж ТӨБЗГ-аар шийдвэр гаргуулж амжаагүй, 2021 он гараад Сайдын тушаал гарч шийдвэрлэнэ гэсэн хариуг өгсөн. Бид 2021 оны эхний хагас жилд багтаан АТҮТ-д бүртгүүлж, ТӨБЗГ-ын 271 дүгээр тогтоолын дагуу данс бүртгэлд тусгана.

2. Балансын данстай холбоотой асуудал:

2.1. Илрүүлэлт:

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны бараа материалын дансны биологийн хөрөнгөнд бүртгэлтэй 65,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 86 толгой адуун сүргийн тооллогоор 43,500.0 мянган төгрөгийн 58 толгой адуу дутуу байв. БОАЖЯ-ны 2020 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн А/95 тушаалаар байгуулагдсан комисс 58 адуун сүрэг дутагдсан асуудлыг шалгахаар 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Төв аймгийн Сэргэлэн сумд ажилласан байна. Тус шалгалтын ажлын үр дүнд үндэслэн 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр Архангай аймаг дах сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Энэ нь бодитой оршин байх ба тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаагаас гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4.үнэн зөв байх; 12 дугаар зүйл Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого, 12.2.3 эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйл Эд хөрөнгийн тооллого явуулах журам, 4/ үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ; гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Эд хөрөнгө дутсанаас үүдэн байгууллага хохирох мөн бараа материалын дансны үлдэгдэл зөрүүтэй байгаагаас үүдэн санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Дутагдсан адуун сүргийн асуудлыг эцэслэн шийдвэрлэж байгууллагыг хохиролгүй болгох.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2017-2020 онд гэрээт адуучнаар ажиллаж байсан Б.Алтансүх нь байгууллагын данс бүртгэлд байсан 79 адуунаас 58 тооны адууг дутааж байгууллагад 43,500.0 мянган төгрөгний хохирол учруулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 3 сарын 9-ний өдрийн А/95 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, дутагдлыг илрүүлсэн. Байгууллага хуулийн хүрээнд харьяаллын дагуу уг хэргийг шийдвэрлүүлэхээр Архангай аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч тогтоолын дагуу шүүх хурал 2 удаа хойшлогдож, шүүх хурлын товыг хүлээж байгаа.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.20			САГ-2021/37/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй байна.	239,468.7	Албан шаардлага	Нягтлан бодогч	С.Одончимэг
2	Хандив, тусламжаар Монгол дахь Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, БОАЖЯ болон Иргэн Г.Ганзоригоос ирсэн 2 автомашиныг хөрөнгөнд бүртгээгүй мөн хүлээн авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж нийт 4,860.4 мянган төгрөгийн зардал гаргасан байна.	4,860.4	Зөвлөмж	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Н.Пүрэвжав
				Нягтлан бодогч	С.Одончимэг
3	Бараа материалын дансны биологийн хөрөнгөнд бүртгэлтэй 65,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 86 толгой адуун сүргийн тооллогоор 43,500.0 мянган төгрөгийн 58 толгой адуу дутуу байв.	43,500.0	Зөвлөмж	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Н.Пүрэвжав
				Нягтлан бодогч	С.Одончимэг
ДҮН		287,829.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 58/А0170078

Улаанбаатар хот

САН-2021/37/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 239,468.7 мянган төгрөгийн 7 гүйлгээг байршуулаагүй, мөн 20 гүйлгээний гэрээ, гэрээ дүгнэсэн актыг огт байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”; 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь, ил тод, бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Пүрэвжав, нягтлан бодогч С.Одончимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
НЬЮ ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ЦЭРЭНХҮҮ

Ж.ҮХЭРТАР